

ТӨСӨЛ

Санхүүгийн зохицуулах хорооны ... оны
... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар
тогтоолын хавсралт

ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦААГ БҮРТГЭХ, ХАДГАЛАХ, АРИЛЖИХ, ӨМЧЛӨХ ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос хаалттай хувьцаат компанийн хувьцааг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага (цаашид “ҮЦТХТ” гэх)-д бүртгэх, хадгалах, өмчлөх эрх шилжүүлэх, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага (цаашид “арилжаа эрхлэх байгууллага” гэх)-ын бүртгэлд бүртгэж, мэргэжлийн хөрөнгө оруулагчдын хооронд арилжих, хяналт тавихтай холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2. Банкны тухай хуулийн 4.2-т заасан банкны системд нөлөө бүхий банкнаас бусад банк, Компанийн тухай хуулийн 13.5-д заасны дагуу шинээр үүсгэн байгуулагдсан хаалттай хувьцаат компани энэ журамд заасан шаардлагын дагуу ҮЦТХТ-д бүртгүүлнэ.

ХОЁР. ҮЦТХТ ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦААГ БҮРТГЭХ

2.1. ҮЦТХТ-ийн бүртгэлд хувьцаагаа бүртгүүлэхээр хүсэлт гаргаж буй хаалттай хувьцаат компани нь дараах шаардлагыг хангасан байна:

2.1.1. хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэн байх;

2.1.2. компанийн хэлбэрийг хаалттай хувьцаат компани болгох тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын болон төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр гарсан байх;

2.1.3. татвар, шүүх болон бусад эрх бүхий байгууллагад хугацаа хэтэрсэн өргүй байх;

2.1.4. зээлийн барьцаанд үүргийн гүйцэтгэл хангуулахаар хувьцаагаа барьцаалаагүй байх.

2.2. ҮЦТХТ нь хувьцаагаа бүртгүүлэхээр хүсэлт гаргасан хаалттай хувьцаат компанийн хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдөрт багтаан хянаж, бүртгэх эсэхийг шийдвэрлэнэ.

2.3. Энэ журмын 2.2-т заасны дагуу татгалзсан шийдвэр гарсан тохиолдолд ҮЦТХТ нь хүсэлт гаргагчид татгалзсан үндэслэл бүхий тайлбарыг албан бичгээр ажлын 2 өдрийн дотор хүргүүлнэ.

2.4. ҮЦТХТ нь хаалттай хувьцаат компанийн хувьцааг бүртгэсэн шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 2 өдрийн дотор холбогдох шийдвэрийн хувийг Хороонд хүргүүлнэ.

ГУРАВ. АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГЫН БҮРТГЭЛД ХУВЬЦААГ БҮРТГЭХ, АРИЛЖИХ

3.1.Арилжаа эрхлэх байгууллага нь нээлттэй хувьцаат компани болох зорилго бүхий хаалттай хувьцаат компанийн хувьцааг бүртгэх, хувьцааг нь мэргэжлийн хөрөнгө оруулагчдын хооронд арилжих үйл ажиллагааг эрхэлнэ.

3.2.Арилжаа эрхлэх байгууллага нь энэ журмын 3.1-т заасан үйл ажиллагааг эрхлэх нэгж, эсхүл ажилтантай байна.

3.3.Арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд хувьцаагаа бүртгүүлэх хүсэлт гаргагч хаалттай хувьцаат компани нь дараах баримт бичгийг хүргүүлнэ:

3.5.1.арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгүүлэх тухай өргөдөл;

3.5.2.хувьцаа эзэмшигчдийн хурлын болон төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр, тэмдэглэл;

3.5.2.нээлттэй хувьцаат компани болохтой холбоотой бэлтгэсэн танилцуулга, 3 жилийн бизнес төлөвлөгөө;

3.5.3. аудитын компаниар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан;

3.5.4.холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажилласан талаарх мэдээлэл;

3.5.5.ҮЦТХТ-ийн бүртгэлд бүртгэлтэй эсэх тодорхойлолт;

3.бусад

3.4.Энэ журмын 3.5.2-т заасан танилцуулгад хувьцааны нэр, төрөл, тоо ширхэг, нэрлэсэн үнэ, компанийн хувьцааны нөлөө бүхий болон хяналтын багцыг эзэмшигчдийн мэдээлэл, хувь эзэмшлийн хэмжээ зэрэг мэдээллийг тусгасан байна.

3.5.Арилжаа эрхлэх байгууллага нь хүсэлт гаргагч компанийн хувьцааг бүртгэх эсэх шийдвэрийг бүрдэл бүрэн хүсэлтийг холбогдох баримт бичгийн хамт хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдөрт хянаж, бүртгэх эсэхийг шийдвэрлэнэ.

3.6.Энэ журмын 3.5-д заасан баримт бичгийн бүрдэл дутуу, нэмэлт тодруулга, мэдээлэл шаардлагатай тохиолдолд арилжаа эрхлэх байгууллага албан бичгээр хүсэлт гаргагчид мэдэгдэх бөгөөд зохих шаардлага хангасан, бүрдэл бүрэн нэмэлт баримт бичгийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан хянаж, бүртгэх эсэхийг шийдвэрлэнэ.

3.7.Энэ журмын 3.7-д заасны дагуу арилжаа эрхлэх байгууллага нь бүртгэх шийдвэр гаргасан тохиолдолд Хороо болон ҮЦТХТ-д ажлын 3 өдрийн дотор мэдэгдэнэ.

3.8.Арилжаа эрхлэх байгууллага нь энэ журмын 3.1-д заасан үйл ажиллагааг эрхлэхтэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулсан журмыг баталж, Хороогоор батламжлуулна.

3.9.Арилжаа эрхлэх байгууллага нь нээлттэй хувьцаат компани болох зорилготой хаалттай хувьцаат компанийн хувьцааг өөрийн бүртгэлд бүртгэхэд тавигдах нөхцөл, шаардлагыг тогтоож болно.

ДӨРӨВ. ҮЦТХТ-ИЙН ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦААНЫ БҮРТГЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ХАСАХ

4.1.ҮЦТХТ хаалттай хувьцаат компанийн хувьцааны бүртгэлд дараах тохиолдолд өөрчлөлт оруулна:

ТӨСӨЛ

4.1.1.компанийн зарласан болон гаргасан хувьцааны тоо ширхэгт өөрчлөлт оруулах шийдвэр гарсан;

4.1.2.компани нь нэгтгэх шийдвэр гарсан;

4.1.3.компани нь хувьцааг хуваах, нэгтгэх, нэрлэсэн үнийг өөрчлөх тухай шийдвэр гаргасан;

4.1.4.бүртгэлтэй хувьцааны нэрийг өөрчлөх шийдвэр гаргасан;

4.1.5.хууль, холбогдох журамд заасан бусад үндэслэл.

4.2.ҮЦТХТ нь дараах тохиолдолд хаалттай хувьцаат компанийн хувьцааг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасна. Үүнд:

4.2.1.компанийн хэлбэрийг өөрчлөх тухай шийдвэр гаргасан;

4.2.2.компани нь хувьцаагаа хасуулах хүсэлт гаргасан,

4.2.2.шүүх болон эрх бүхий төрийн байгууллагын шийдвэрээр татан буулгах шийдвэр гаргасан.

4.3.Хаалттай хувьцаат компани нь өөрийн хүсэлтээр хувьцаагаа ҮЦТХТ-ийн бүртгэлээс хасуулах тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

4.4.ҮЦТХТ нь хаалттай хувьцаат компанийн хувьцааг өөрийн бүртгэлээс хассан нөхцөлд бүртгэлээс хассан талаарх шийдвэр, дүгнэлтийг Хороонд ажлын 3 өдөрт багтаан ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан мэдээлнэ.

4.5. ҮЦТХТ нь хувьцааг хадгаламжаас хасахтай холбоотой шаардлагатай гэж үзсэн нэмэлт баримт бичгийг ирүүлэхийг хаалттай хувьцаат компаниас шаардаж болно.

4.6.ҮЦТХТ нь хаалттай хувьцаат компани хувьцаа эзэмшигчийн өмнө хүлээсэн аливаа хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд өөрийн бүртгэлээс хасахаас татгалзана.

ТАВ. ҮЦТХТ ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦААГ ХАДГАЛАХ

5.1.ҮЦТХТ нь хаалттай хувьцаат компанийн хувьцааг төрөл тус бүрээр нэгдсэн дугаар (код) өгч бүртгэнэ.

5.2.ҮЦТХТ нь хаалттай хувьцаат компани хувьцааг хадгалахтай холбоотой харилцааг зохицуулсан гэрээг байгуулна.

5.3.Энэ журмын 5.2-т заасан хувьцааны хадгаламжийн гэрээнд хадгаламжийн хэлбэр, хадгалуулах хувьцааны төрөл, тоо ширхэг, хадгаламжийн үйлчилгээний хөлсний хэмжээ, хөлс төлөх хугацаа, хадгаламжийн гэрээг цуцлах нөхцөл, гэрээгээр хүлээсэн үүргийг гүйцэтгээгүйгээс үүсэх хариуцлагыг тодорхой тусгасан байна.

ЗУРГАА. ҮЦТХТ ХУВЬЦААНЫ ӨМЧЛӨХ ЭРХ ШИЛЖСЭНИЙГ БҮРТГЭХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

6.1.Хувьцааны өмчлөх эрх шилжүүлэн авч байгаа этгээд өмчлөх эрх шилжүүлэн бүртгүүлэх хүсэлтийг холбогдох баримт бичгийн хамт худалдах, худалдан авах гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор ҮЦТХТ-д хүргүүлнэ.

6.2.ҮЦТХТ нь хувьцааны өмчлөх эрх шилжсэнийг бүртгэхдээ дараах баримт бичгийг үндэслэн шийдвэрлэнэ:

6.2.1.худалдах, худалдан авах гэрээний эх хувь;

6.2.2.худалдах, худалдан авах гэрээний дагуу хийгдсэн төлбөр төлөгдсөн баримтын хуулбар;

6.2.3.талуудын иргэний үнэмлэхийн хуулбар.

6.3.ҮЦТХТ нь шүүх болон эрх бүхий төрийн байгууллагаас гаргасан тогтоол, шийдвэр, эсхүл үл маргах журмаар өмчлөх эрх шилжүүлэх тохиолдолд дараах баримт бичгийг үндэслэнэ:

6.3.1.хувьцаа эзэмшигчийн хүсэлт, гэрээ дүгнэсэн акт;

6.3.2.шүүхийн шийдвэр, гүйцэтгэх хуудас.

6.4.ҮЦТХТ нь энэ журамд заасан өмчлөх эрхийн гүйлгээтэй холбоотой баримт бичгийн бүрдэл хангасан тохиолдолд өмчлөх эрх шилжүүлэх бөгөөд шаардлага хангаагүй тохиолдолд өмчлөх эрхийг шилжүүлж, бүртгэхээс татгалзана.

ДОЛОО. БУСАД

7.1.Хаалттай хувьцаат компани нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлын зарыг хүргэхдээ Хорооноос баталсан хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмыг баримтална.

7.2.Хаалттай хувьцаат компани нь 50 буюу түүнээс доош тооны хувьцаа эзэмшигчтэй бол энэ журмын 7.1-д заасан журмыг мөрдөхгүй байж болно. Энэ тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх арга, журмыг компанийн дүрэмд заавал тусгана.

7.3.Хаалттай хувьцаат компани нь тухайн санхүүгийн жилд ногдол ашиг хуваариалаар шийдвэрлэсэн тохиолдолд ҮЦТХТ-өөр дамжуулан хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг хуваарилж болно.

7.4.Хаалттай хувьцаат компани нь энэ журмын 7.3-т заасны дагуу ногдол ашгийг хуваарилсан өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор холбогдох тайланг Хороонд хүргүүлнэ.